



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А1883

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т шилжүүлэн, холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 500,000,000.0 (таван зуун сая) төгрөгийг “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний шинэчилсэн жагсаалт”-ын “Х1.1”-д тусгагдсан “Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэлт (Улаанбаатар хот)”-ийн хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Улаанбаатар лифт” ОНӨТҮГ (Д.Ган-Эрдэнэ)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР

1110203579

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
сарын 07-ны өдрийн
захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ЦАХИЛГААН
ШАТНЫ ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ЖАГСААЛТ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	5 дугаар байрны 4 дүгээр орцны цахилгаан шат (БЗД, 15 дугаар хороо)	2023	2023	130.0	130.0
2	9 дүгээр байр 4 дүгээр орцны цахилгаан шат (СБД, 7 дугаар хороо)	2023	2023	120.0	120.0
3	6А байрны 1 дүгээр орцны цахилгаан шат (БГД)	2023	2023	125.0	125.0
4	6Б байрны 2 дугаар орцны цахилгаан шат (БГД)	2023	2023	125.0	125.0
ДҮН				500.0	500.0